



MSE: 

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН МАТЕРИАЛ**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2,
Ард Холдингс ХК-ийн байр, 2 давхарт, м3вг: цэнэг эрдэмтэй өнгөлөх,
Утас: 77078080, 11-321899, Цахим хаяг: info@ardholdings.com

2019 он 8 сар 9 өдөр

Дугаар 19 / 11

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Эчнээ санал хураалт явуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн эчнээ санал хураалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг томилох, сонгох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтаар шийдвэрлүүлж, эчнээ санал хураалт явуулахыг зөвшөөрсүгэй.
2. Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 8 сарын 15-ны өдрөөр тогтоосугай.
3. Эчнээ санал хураалт явуулах зарыг 2019 оны 8 сарын 12 -ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу өдөр тутмын сониноор дамжуулан нийтэд мэдээлсүгэй.
4. Эчнээ санал хураалтыг 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөс 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл явуулсугай.
5. Дараах нэр бүхий хүмүүсийг эчнээ санал хураалт зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Эчнээ санал хураалт зохион байгуулах комиссын дарга:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг

Эчнээ санал хураалт зохион байгуулах комиссын гишүүд:

Маркетинг хариуцсан захирал Ц.Должин;

Санхүү эрхэлсэн захирал Б.Золбоо;

Ерөнхий нягтлан бодогч Г.Сэлэнгэ;

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Хулан;

Компанийн нарийн бичгийн дарга А.Батболд;

6. Эчнээ санал хураалт явуулах саналын хуудасны загварыг нэгдүгээр хавсралтаар, эчнээ санал хураалтын зарыг нийтэд хүргэх зарын загварыг хоёрдугаар хавсралтаар, эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

7. Дараах нэр бүхий хүмүүсийг эчнээ санал хураалтын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

Ард Секюритиз УЦК ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Золзаяа

Тооллогын комиссын гишүүд:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дотоод аудитор М.Мөнх-Эрдэнэ

Ард Секюритиз УЦК ХХК-ийн брокер Долгорсүрэн

Ард Даатгал ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал Т.Батцэнгэл

9. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эчнээ санал хураалтыг явуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг эчнээ санал хураалт зохион байгуулах комисст даалгасугай.

10. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Ганхуягт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П.БАТБАЯР



Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2,
Ард Холдингс ХК-ийн байр, 2 давхарт, w3w: цэнэгэрдэмтэй.өнгөлөх,
Утас: 77078080, 11-321899, Цахим хаяг: info@ardholdings.com

2019 он 8 сар 16 өдөр

Дугаар 19/12

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйл, СЗХ-ны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батласан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн эчнээ санал хураалт явуулах тухай 19/11 тоот тогтоолд дараах өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

1. Тогтоолын 2-р зүйлд “Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 8 сарын 31-ний өдрөөр тогтоосугай” гэж өөрчлөх,
2. Тогтоолын 4-р зүйлд “Эчнээ санал хураалтыг 2019 оны 9 дугаар сарын 2-ны өдрөөс 2019 оны 10 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл явуулсугай” гэж өөрчлөх,
3. Тогтоолын 7-р зүйлийг бүхэлд нь хүчингүйд тооцож, дараах байдлаар өөрчлөх.
Үүнд: “Дараах нэр бүхий хүмүүсийг эчнээ санал хураалтын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

Глобал Дийл ХХН-ийн хуульч Баяржаргал овогтой Мөнхзул

Тооллогын комиссын гишүүн:

Глобал Дийл ХХН-ийн хуульч Нарантуяа овогтой Оролжмаа

4. Тогтоолд “Эчнээ саналын хуудас, эчнээ санал хураалтаас гарах шийдвэрийн төсөл, танилцуулга зэрэг холбогдох баримт бичгийг бэлэн болгож, 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.” гэсэн заалт нэмэх

5. Тогтоолд “Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас болон холбогдох баримт бичгийг 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Холдингсын байрны 2 давхар болон үнэт цаасны компаниудаар дамжуулан танилцуулсугай” гэсэн заалт нэмэх,

6. Тогтоолд “Хувьцаа эзэмшигчдээс эчнээ саналын хуудсыг 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 16.00 цаг хүртэл Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Холдингсын байрны 2 давхарт хүлээн авч, эчнээ санал хураалт явуулсугай” гэж нэмэх

7. Тогтоолын өөрчлөлтийг холбогдох байгууллагуудад мэдэгдэж, эчнээ санал хураалтыг зохион байгуулахыг Зохион байгуулах комиссын дарга Ч.Ганхуягт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  П.БАТБАЯР

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК САНАЛ АВАХ ХУУДАС
(Хэлэлцэх асуудал №1)

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтын саналыг 2019 оны 9 сарын 2-ны өдрөөс 2019 оны 10 сарын 11-ны өдөр хүртэл Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн төв оффис болох Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Холдингсын байр, 2 давхарт хүлээн авна.

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
Ердийн гишүүн		
1	Чулуун овогтой Ганхуяг	
2	Хишигдорж овогтой Батхишиг	
3	Бруно Е. Рашле	
4	Авир овогтой Сүхдорж	
5	Одончимэд овогтой Одбаяр	
Хараат бус гишүүн		
1	Пүрэвжаргал овогтой Батбаяр	
2	Мөнх-Очир овогтой Сэргэлэн	
3	Чулуун овогтой Мөнхбат	
4	Жим Андерсон	
5	Михаил Зелдович	
6	Арнауд Вентура	

Санамж: ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн

байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй ($100 \times 9 \text{ гишүүн} = 900$) болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____/...../
Санал авах хуудсыг үйлдсэн 2019 оны ...сарын ...-ны өдөр
Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх:
Тооллогын комиссын дарга _____/...../
Хүчингүйд тооцсон бол шалтгаан:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 8 сарын 9-ны өдрийн
19/11 тоот тогтоолын 2-р хавсралт

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 8 сарын 9-ны өдрийн 19/11 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалт явуулах тухай зарлаж байна.

Эчнээ санал хураалтаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох тухай;
Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь: 2019 оны 8 сарын 31-ний өдөр байна.

Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга;

Эчнээ санал хураалтыг 2019 оны 9 сарын 2-ны өдрөөс 2019 оны 10 сарын 11-ний өдөр хүртэл явуулна. Хувьцаа эзэмшигч Та бүхэн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан саналаа өгөх боломжтой ба брокер дилерийн компаниудаар дамжуулан санал авах хуудсаар саналаа өгөх боломжтой. Мөн Та бүхэн 8 сарын 21-ний өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Холдингсын байр, 2 давхар хаягаар болон үнэт цаасны компаниудаар дамжуулан эчнээ санал хураалтын материалтай танилцах боломжтой. Эчнээ саналын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд ирж болон эчнээ санал хураалт зохион байгуулах комиссын утсаар холбоо барьж авна уу.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Холдингсын байр, 2 давхар

Утас: 7707 8080, 9944 1747

И-мэйл хаяг: info@ardholdings.com

ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 8 сарын 9-ны өдрийн
19/11 тоот тогтоолын 3-р хавсралт

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧДИЙН
ТАНИЛЦУУЛГА**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) байна. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-н дүрмийн 8.2-т зааснаар ТУЗ нь 9 (ес)-өөс 11 (арван нэг) гишүүнээс бүрдэх бөгөөд 1/3 нь хараат бус гишүүн байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД:

1. Чулуун овогтой Ганхуяг
2. Хишигдорж овогтой Батхишиг
3. Авир овогтой Сүхдорж
4. Бруно Рашле
5. Одончимэд овогтой Одбаяр

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД:

1. Пүрэвжаргал овогтой Батбаяр
2. Мөнх-Очир овогтой Сэргэлэн
3. Чулуун овогтой Мөнхбат
4. Жим Андерсон
5. Михаил Зелдович
6. Арнауд Вентура

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Чулуун**

Өөрийн нэр: **Ганхуяг**

Боловсрол: **Дээд**

Мэргэжил: **Эдийн засагч, Банк санхүүгийн менежмент**

Одоо эрхэлж байгаа албан тушаал:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн

Гүйцэтгэх захирал



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил
Унгар	Budapest University of	1993	1997	Эдийн засагч
Будапешт	Economic Sciences			(бакалавр)
АНУ	Stonier/ABA	2002	2002	Мэргэжил дээшлүүлэх сургалт
АНУ	Shore bank	2002	2002	
АНУ	Бүтээлч Манлайллын төв	2005	2005	Манлайллын хөтөлбөр
АНУ	Харвард Кеннеди			21-р зууны Дэлхийн Манлайлал
	Их Сургууль	2010	2010	ба Олон нийтийн бодлого

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон	Гарсан
ХасБанк	Гүйцэтгэх захирал	1998	2009
ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК	Гүйцэтгэх захирал	2009	2010
Сангийн Дэд сайд	Сангийн Дэд сайд	2010	2012
И Ай Ти ХХК	ТУЗ-ийн Дарга	2012	2014
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	Гүйцэтгэх захирал	2014	Одоог хүртэл
	ТУЗ-ийн гишүүн		

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Хишигдорж**

Өөрийн нэр: **Батхишиг**

Боловсрол: **Дээд**

Мэргэжил: **Улс төр судлаач, эрх зүйч**

Одоо эрхэлж байгаа албан тушаал:

Хишиг Арвин Индустриал ХХК-ийн Гүйцэтгэх захирал,



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил
Хятад	Шанхай хотын Тонжи Их Сургууль	2010	2014	Улс төр судлаач, нийтийн удирдлага (бакалавр)
Монгол	Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль	2014	2015	Олон улсын эрх зүйч (магистр)

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон	Гарсан
Хишиг Арвин Индустриал ХХК	Бизнес хөгжлийн менежер	2014	2015
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	ТУЗ-ийн гишүүн	2017	Одоог хүртэл
Хишиг Арвин Индустриал ХХК	Гүйцэтгэх захирал	2015	Одоог хүртэл

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Авир**
Өөрийн нэр: **Сүхдорж**
Боловсрол: **Дээд**
Мэргэжил: **Компьютерийн инженер**
Одоо эрхэлж байгаа албан тушаал:
Грэйф Сити Монгол ХХК-ийн Ерөнхий Захирал



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил
УБ	Нийслэлийн 1-р ЕБС	1967	1969	ЕБ
Украин	Киев, Политехник ДС	1970	1975	Компьютерын инженер

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон	Гарсан
Улсын Төлөвлөгөөний Комисс			
Тооцоолох Төв	Ахлах инженер	1975	1988
Улсын банкны тооцоолох төв	Дарга	1988	1991
	Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга		
БСБ Сервис ХХК	Гүйцэтгэх захирал	1991	2007
ГрэйпСити ХХК	Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга	2000	2008
	Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх		
Инкомнет ХХК	захирал	2001	2016
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	ТУЗ-ийн гишүүн	2018	Одоог хүртэл
МОСТ Финтек ХХК	Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх	2008	Одоог хүртэл
	захирал		

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Рашле**

Өөрийн нэр: **Бруно**

Боловсрол: **Дээд**

Мэргэжил: **Барилгын инженер, үйлдвэрийн инженер**

Одоо эрхэлж байгаа албан тушаал:

Schroder AdvEq Holding AG дэд дарга



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил
Швейцар	Швейцар Улсын Их Сургууль	1965	1973	
	Швейцар Улсын Технологийн			
Швейцар	Их Сургууль	1974	1978	Барилгын инженер (магистр)
Америк	Стэнфорд Их Сургууль	1982	1983	Үйлдвэрийн инженер (магистр)
Америк	Харвардын Их Сургууль	1990	1990	Дээд төвшний менежментийн программ

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон	Гарсан
Барилга төлөвлөлт менежментийн хүрээлэн	Судалгаа, туслах	1976	1980
Хэйек Инженеринг Эй Жи компани	Төслийн инженер	1980	1982
Мотор-Колумбус Эй Жи компани	Гүйцэтгэх захирал	1983	1993
Баллард Повер Системс	ТУЗ-ийн гишүүн	1989	1998
Эс Эп Эс Стэдлер компани	Ерөнхий менежер	1993	1996
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	ТУЗ-ийн гишүүн	2016	Одоог хүртэл
Schroder AdvEq Holding AG	Үүсгэн байгуулагч	1997	Одоог хүртэл
	ТУЗ-ийн дарга		

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр : **Одончимэд**
Өөрийн нэр : **Одбаяр**
Боловсрол : **Дээд**
Мэргэжил : **Багш, Хуульч**
Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал :
**Эрдэнэс Монгол ХХК-ийн Бизнес,
Стратеги төлөвлөлт эрхэлсэн дэд захирал,**



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил
ЗХУ	Багшийн Их Сургууль	1984	1988	Багш (бакалавр, магистр)
Монгол	Отгонтэнгэр Их Сургууль	1996	1998	Хуульч, Эрх зүйч (бакалавр)

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон Гарсан	
УБДС	Багш	1988	1992
Монгол-Хятадын хамтарсан	Монголын талын		
Си Эм Эйч	Гүйцэтгэх захирал	2000	2002
МИАТ ХК Бээжин дэх төлөөлөгчийн газар	Менежер	2002	2005
Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ	Атташе, 3-р нарийн бичгийн дарга, Консул	2005	2010
Монгол Улсын Засгийн Газар	МУ-ын Ерөнхий сайдын зөвлөх	2010	2012
Чингис Хаан зочид буудал цогцолбор	Гүйцэтгэх захирал	2012	2016
Алтай Холдинг	Дэд ерөнхийлөгч	2012	2016
Гашуун Сухайт Автозам	ТУЗ-ийн гишүүн	2016	Одоог хүртэл
Бадрах Энержи	ТУЗ-ийн гишүүн	2016	Одоог хүртэл
Шивээ-Овоо	ТУЗ-ийн дарга	2016	Одоог хүртэл
Эрдэнэс Стил	ТУЗ-ийн дарга	2016	Одоог хүртэл
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	ТУЗ-ийн гишүүн	2014	Одоог хүртэл
Эрдэнэс Монгол	Стратеги төлөвлөлт эрхэлсэн дэд захирал	2016	Одоог хүртэл

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Пүрэвжаргал**
Өөрийн нэр: **Батбаяр**
Боловсрол: **Дээд**
Мэргэжил : **Эдийн засагч, Санхүүч**
Одоо эрхэлж байгаа албан тушаал:
Resilience Mongolia Mining Pty ТУЗ-ийн гишүүн



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил
ИБУИНВУ	Swansea University	1997	2000	Эдийн засагч (бакалавр)
ИБУИНВУ	London Business School	2003	2005	Санхүү (магистр)

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон	Гарсан
Сангийн яам	Эдийн засагч	2000	2001
ЕСБХБ, Лондон хот	Natural Resources Banker	2001	2010
Scedrock Mongolia LLC	Гүйцэтгэх захирал	2010	2013
Интер Групп ХХК	ТУЗ-ийн дарга	2011	2014
Хаан Банк	ТУЗ-ийн гишүүн	2014	2015
Resilience Mongolia Mining Pty	Байгууллагын Банкны захирал	2015	Одоог хүртэл
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	ТУЗ-ийн дарга	2018	Одоог хүртэл

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр : **Мөнх-Очир**
Өөрийн нэр : **Сэргэлэн**
Боловсрол : **Дээд**
Мэргэжил : **Нягтлан бодогч**
Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал :
ТТДС ХХК-н захирал,



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил
Монгол	Бизнес олон улсын дээд сургууль			Нягтлан бодогч (бакалавр)
Япон	Исита Коллеж			Менежмент (бакалавр)

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон	Гарсан
МАС ХХК	Захирал, менежер	1997	2000
ТСИ	Захирал	1999	2015
Техник Технологийн дээд сургууль	Захирал	2005	Одоог хүртэл
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	ТУЗ-ийн гишүүн	2014	Одоог хүртэл

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Чулуун**
Өөрийн нэр: **Мөнхбат**
Боловсрол: **Дээд**
Мэргэжил: **Эрх зүйч**
Одоо эрхэлж байгаа албан тушаал:
Саусгоби Сэндс ХХК-н Ерөнхийлөгч,
Гүйцэтгэх захирал,



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил
УБ	52-р сургууль	1977	1987	Бүрэн дунд
ЗХУ	ДЯЯ-ны дээд сургууль	1989		Эрх зүйч (бакалавр)
Шинэ Зеланд	Вайкатогийн Их сургууль	1998		Төрийн бодлого, төрийн удирдлага (магистр)

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон	Гарсан
Peace Winds Japan	Төслийн захирал	1999	2001
Дэлхийн банк	Төслийн зохицуулагч	2001	2003
Азийн хөгжлийн банк	Хөтөлбөрийн захирал	2003	2005
Улсын ерөнхий прокурорын газар	Ерөнхий прокурорын орлогч	2005	2012
Саусгоби ресурс	Зөвлөх	2012	2013
Саусгоби сэндс ХХК	Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал	2013	Одоог хүртэл
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	ТУЗ-ийн гишүүн	2018	Одоог хүртэл

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Андерсон**
Өөрийн нэр: **Жеймс**
Боловсрол: **Дээд**
Мэргэжил: **Санхүү**
Одоо эрхэлж байгаа албан тушаал:
**Алтерфин компанийн Хөрөнгө оруулалтын
хорооны гишүүн**



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил
Нью-Йорк	Lubin бизнесийн сургууль			Санхүү (магистр)
Фэрфилд	Fairfield их сургууль			Санхүү

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон	Гарсан
DAI -Босни ба Герцеговин	Зээлийн ажилтан	1998	
Олон улсын санхүүгийн корпорац (IFC) - Казахстан	Бүс нутгийн хөрөнгө оруулалтын ажилтан	1999	2001
Мейкон төслийн хөгжил хөтөлбөр (MPDF) - Вьетнам		2001	2002
Хас банк - Монгол	Ахлах техникийн зөвлөх	2003	2005
Mercury Corps - Монгол	Санхүү үйлчилгээ хариуцсан менежер	2005	2011
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөрөнгийн Хөгжлийн Сан - Лаос	Техникийн ерөнхий зөвлөх	2011	2013
Компаньон банк - Киргиз улс	Эрсдэлийн ахлах мэргэжилтэн, ахлах техникийн зөвлөх	2013	2018
Азийн зээлийн сан - Казахстан	Зөвлөх, ТУЗ-ийн дарга	2013	Одоог хүртэл
Алтерфин - Бельги улс	Хөрөнгө оруулалтын хорооны гишүүн	2018	Одоог хүртэл
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	ТУЗ-ийн гишүүн	2019	Одоог хүртэл

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Эцэг /эх/-ийн нэр: **Зелдович**
Өөрийн нэр: **Михаил**
Боловсрол: **Дээд**
Мэргэжил: **Түүх, улс төр судлал**
Одоо эрхэлж байгаа албан тушаал:
Green Leafe Capital - Хяналтын зөвлөлийн дарга



Хоёр. Боловсрол

Хаана	Сургуулийн нэр	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил
Массачусетс, АНУ	Харвардын хуулийн сургууль	1997	2001	ОУ-ын эдийн засаг, (доктор)
Массачусетс, АНУ	Fletcher хууль, эрх зүйн сургууль	1998	2001	Бизнесийн хууль ОУ-ын худалдаа (магистр)
Виржини, АНУ	Виллиам, Маригийн коллеж	1997		Түүх, улс төр судлал (бакалавр)

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон	Гарсан
Корпорацийн санхүү ба зөвлөх		2006	2007
Капиталын олон улсын хувийн өмчийн сан (CIPEF)	Хөрөнгө оруулалтын ажилтан, ТУЗ-н гишүүн	2007	2013
Трафигура Монголиа ХХК	Гүйцэтгэх захирал	2016	Одоог хүртэл
Cocoon Capital	Хяналтын зөвлөлийн дарга	2017	Одоог хүртэл
Green Leafe Capital	Хяналтын зөвлөлийн дарга	2018	Одоог хүртэл
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	ТУЗ-ийн гишүүн	2019	Одоог хүртэл

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ АНКЕТ**Нэг. Ерөнхий мэдээлэл**

Эцэг /эх/-ийн нэр: **Арнауд**
 Өөрийн нэр: **Вентура**
 Боловсрол: **Дээд**
 Одоо эрхэлж байгаа албан тушаал:
Баобаб Группийн гүйцэтгэх захирал

**Хоёр. Боловсрол**

Хаана	Сургуулийн нэр	Элссэн	Төгссөн	Эзэмшсэн мэргэжил
Франц	La Sorbonne		1994	Философи (мастер)
Франц	EFREI		1996	Телеком инженер

Гурав. Ажлын туршлага

Байгууллагын нэр	Албан тушаал	Орсон	Гарсан
PlaNet Finance	Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал	1998	2006
Baobab Group	Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал	2007	Одоог хүртэл

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 11-ний өдөр

№__

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 9 сарын 2-ны өдрөөс 2019 оны 10 сарын 11-ний өдөр хүртэл явуулсан эчнээ санал хураалт болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр

1.овогтой
2.овогтой
3.овогтой
4.овогтой
5.овогтой

2.Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр

1.овогтой
2.овогтой
3.овогтой
4.овогтой
5.овогтой
6.овогтой нарыг тус тус томилсугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

П.БАТБАЯР

Анхаарал хандуулсанд баярлалаа

Хүчтэй. Хамтдаа.